

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/137/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.ЦЭЦЭГБАДАМ ТАНАА

2021.02.25 № 2/102
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, суралцагчийн сурлагын түвшин зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


021020259

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН / төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,223,609.98	87,130,377.18
33	АВЛАГА	00.00	4,076,176.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	177,226.00
335	Бусад авлага	00.00	3,898,950.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,898,950.00
35	БАРАА МАТЕРИАЛ	92,223,609.98	83,054,201.18
351	Түүхий эд материал	00.00	3,300,000.00
35130	Эм боох материал	00.00	3,300,000.00
354	Хангамжийн материал	92,223,609.98	78,814,201.18
35410	Бичиг хэргийн материал	4,409,908.00	5,407,738.00
35420	Аж ахуйн материал	60,149,131.98	45,600,663.18
35450	Барилгын засварын материал	00.00	3,130,500.00
35460	Хүнсний материал	12,670,970.00	4,680,500.00
35470	Бусад хангамжийн материал	14,993,600.00	19,994,800.00
35600	Мал амьтад	00.00	940,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,420,479,679.63	5,416,427,376.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,420,479,679.63	5,416,427,376.01
392	Биет хөрөнгө	2,400,479,679.63	5,396,427,376.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,305,274,668.93	4,997,863,488.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,609,255.00	-85,218,510.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,000.00	-23,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,247,005.00	196,223,357.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-157,114,632.72	-165,169,198.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	176,019,973.00	218,161,371.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-125,423,861.58	-133,851,887.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	24,312,654.00	330,226,768.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,163,806.20	-2,327,612.40
39217	Ном	36,936,934.20	40,519,598.66
393	Биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39301	Програм хангамж	1,004,000.00	1,004,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,004,000.00	-1,004,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,512,703,289.61	5,503,557,753.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,512,703,289.61	5,503,557,753.19
51	Засгийн газрын хувь оролцоо	2,512,703,289.61	5,503,557,753.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,910,020,624.00	1,910,020,624.00
51101	Өмч: - төрийн	1,910,020,624.00	1,910,020,624.00
512	Хуримтлагдсан үр дүн	-420,548,101.48	2,568,842,362.10
51210	Өмнөх үеийн үр дүн	-392,764,578.88	-429,708,270.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	3,000,014,632.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	-27,783,522.60	1,023,230,767.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,512,703,289.61	5,503,557,753.19

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	918,047,690.20	4,202,190,149.06

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,733,280.20	3,061,943,849.06
120	Нийтлэг татварын бус орлого	20,733,280.20	3,056,283,849.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,733,280.20	3,056,283,849.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	2,400,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,183,280.20	3,053,883,849.06
122	Тусламжийн орлого	00.00	5,660,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	5,660,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,314,410.00	142,572,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	795,923,800.00	997,673,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,530,510.00	7,419,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,766,510.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,764,000.00	6,919,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,860,100.00	135,153,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,860,100.00	135,153,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	945,831,212.80	1,202,175,516.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	945,831,212.80	1,202,175,516.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,371,277.80	1,089,251,832.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,804,800.00	744,804,365.00
210101	Үндсэн цалин	462,540,600.00	512,332,523.00
210102	Нэмэгдэл	123,487,800.00	169,475,216.00
210104	Урамшуулал	45,776,400.00	62,996,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,917,400.00	93,853,615.10
210201	Тэтгэврийн даатгал	51,918,000.00	63,956,599.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,242,300.00	7,503,829.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,024,100.00	6,003,443.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248,500.00	1,489,569.45
210205	Эрүүл мэндийн даатгал	12,484,500.00	14,900,173.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,187,716.00	132,017,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,195,216.00	4,408,016.00
210302	Түлш, халаалт	46,243,600.00	115,309,284.00
210303	Цэвэр, бохир ус	17,748,900.00	12,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,408,470.00	17,141,980.00
210401	Бичиг хэрэг	4,103,250.00	1,704,970.00
210402	Тээвэр, шатахуун	5,832,585.00	2,463,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,120,385.00	675,000.00
210404	Ном, хэвлэл	151,850.00	3,864,580.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	203,200.00	212,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,997,200.00	8,221,300.00
2105	Нормативт зардал	45,680,180.00	31,935,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	251,200.00	2,672,100.00
210502	Хоол, хүнс	45,120,980.00	28,955,820.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	308,000.00	308,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,653,697.00	858,500.00
210604	Урсгал засвар	5,653,697.00	858,500.00
2107	Томилолт, зочны зардал	349,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	349,600.00	00.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249,700.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	249,700.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,119,714.80	68,248,152.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,576,700.00	4,052,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,092,439.00	3,940,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,450,575.80	60,255,652.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,459,935.00	112,923,683.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,648,000.00	12,277,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,648,000.00	12,277,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	811,935.00	100,255,883.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	811,935.00	100,255,883.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	390,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	390,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,783,522.60	3,000,014,632.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,783,522.60	3,000,014,632.38

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН / төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	899,864,410.00	1,142,646,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,550,000.00	2,400,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,550,000.00	2,400,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,550,000.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550,000.00	2,400,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	897,314,410.00	1,140,246,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	795,923,800.00	997,673,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,530,510.00	7,419,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,766,510.00	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,764,000.00	6,919,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,860,100.00	135,153,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,860,100.00	135,153,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	887,194,910.00	1,142,646,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	887,194,910.00	1,142,646,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,656,910.00	1,028,258,616.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,693,600.00	744,981,591.00
210101	Үндсэн цалин	461,429,400.00	512,509,749.00

210102	Нэмэгдэл	123,487,800.00	169,475,216.00
210104	Урамшуулал	45,776,400.00	62,996,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,028,600.00	93,853,615.10
210201	Тэтгэврийн даатгал	53,029,200.00	63,956,599.75
210202	Тэтгэмжийн даатгал	6,242,300.00	7,503,829.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,024,100.00	6,003,443.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248,500.00	1,489,569.45
210205	Эрүүл мэндийн даатгал	12,484,500.00	14,900,173.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,942,300.00	132,017,300.00
210301	Гэрэл, цахилгаан	7,449,800.00	4,408,016.00
210302	Түлш, халаалт	34,743,600.00	115,309,284.00
210303	Цэвэр, бохир ус	17,748,900.00	12,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,428,310.00	9,281,080.00
210401	Бичиг хэрэг	539,300.00	522,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,832,610.00	2,476,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	679,500.00	625,000.00
210404	Ном, хэвлэл	4,140,000.00	4,194,580.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,700.00	212,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,977,200.00	1,250,200.00
2105	Нормативт зардал	50,732,900.00	34,169,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,600.00	5,812,100.00
210502	Хоол, хүнс	48,735,800.00	23,400,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,655,500.00	4,957,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,136,100.00	2,745,500.00
210604	Урсгал засвар	3,136,100.00	2,745,500.00
2107	Томилолт, зочны зардал	349,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	349,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249,700.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	249,700.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,765,300.00	10,817,630.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,738,600.00	3,790,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,026,700.00	7,027,630.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,538,000.00	114,387,683.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,726,065.00	12,277,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,726,065.00	12,277,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	811,935.00	100,255,883.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	811,935.00	100,255,883.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,854,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	390,600.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,464,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,890,020,624.00	5,612,521.00	-384,935,578.08	1,510,697,566.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,890,020,624.00	5,612,521.00	-384,935,578.08	1,510,697,566.92
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,829,000.80	-7,829,000.80
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	-420,548,101.48	2,512,703,289.61
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	-420,548,101.48	2,512,703,289.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-9,160,168.80	-9,160,168.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	-429,708,270.28	2,503,543,120.81
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	3,000,014,632.38	3,000,014,632.38
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	2,570,306,362.10	5,503,557,753.19

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН / төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,135,227,200.00	1,034,580,716.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,227,200.00	1,034,580,716.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,108,797,300.00	1,022,303,516.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	794,975,400.00	744,981,591.00
210101	Үндсэн цалин	534,171,400.00	512,509,749.00
210102	Нэмэгдэл	204,716,000.00	169,475,216.00
210104	Урамшуулал	56,088,000.00	62,996,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,322,000.00	93,853,615.10
210201	Тэтгэврийн даатгал	75,522,700.00	63,956,599.75
210202	Тэтгэмжийн даатгал	7,949,800.00	7,503,829.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,360,100.00	6,003,443.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,589,900.00	1,489,569.45
210205	Эрүүл мэндийн даатгал	15,899,500.00	14,900,173.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	132,017,300.00	132,017,300.00
210301	Гэрэл, цахилгаан	8,194,800.00	4,408,016.00
210302	Түлш, халаалт	106,073,600.00	115,309,284.00
210303	Цэвэр, бохир ус	17,748,900.00	12,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,694,500.00	5,481,980.00
210401	Бичиг хэрэг	539,300.00	522,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,476,400.00	2,476,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	662,500.00	625,000.00
210404	Ном, хэвлэл	479,400.00	395,480.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	259,700.00	212,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,277,200.00	1,250,200.00
2105	Нормативт зардал	55,938,400.00	34,169,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,816,600.00	5,812,100.00
210502	Хоол, хүнс	45,158,100.00	23,400,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,963,700.00	4,957,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,136,100.00	2,745,500.00
210604	Урсгал засвар	3,136,100.00	2,745,500.00
2107	Томилолт, зочны зардал	349,600.00	00.00
210702	Дотоод албан томилолт	349,600.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000.00	392,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	392,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8972000.00	8661630.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,134,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,572,000.00	6,527,630.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26429900.00	12277200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,429,900.00	12,277,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,429,900.00	12,277,200.00

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,135,227,200.00	1,034,580,716.10
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	997,673,800.00	897,417,916.10
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	997,673,800.00	897,417,916.10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	135,153,400.00	134,762,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	135,153,400.00	134,762,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,400,000.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	2,400,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	63
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40
620003	Үйлчлэх ажилтан	22	22

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,419,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,919,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,455,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,799,100.00
210404	Ном, хэвлэл	3,799,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,656,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,656,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,464,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,464,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,464,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	500,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,419,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,419,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,919,100.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Т.Цэцэгбадам танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, эд хөрөнгийн бүртгэл, тайлагналын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтай сумын ерөнхий боловсролын сургууль нь эрхэм зорилгоо “Суралцагч, багш, эцэг эхийн гурвалсан холбоог бэхжүүлэн, хүүхдэд ээлтэй, бүгдэд нээлттэй, сургууль байж чадварлаг багш, чанартай сургалт, төлөвшилтэй суралцагч бий болгон сургалтын таатай орчин бүрдүүлж, соёлтой үйлчилгээ түгээн ажиллахад оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл нь “Бага, дунд, ерөнхий боловсрол олгох” гэж заасан байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль, журам стандартад нийцсэн ч санхүү, бүртгэлийн шинэчлэгдсэн хууль тогтоомж, заавар журамд нийцүүлэн шинэчлэлт, баяжуулалт хийгдээгүй байна.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод болон бусад хяналт шалгалтууд хийгдээгүй байна.

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 945831.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9458.3 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1203639.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12036.3 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2989390.5 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	92,223.6	87,130.4	-5,093.2
33	Авлага	00.0	4,076.2	4,076.2
35	Бараа материал	92,223.6	83,054.2	-9,169.4
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,420,479.7	5,416,427.4	2,995,947.7
39	Үндсэн хөрөнгө	2,420,479.7	5,416,427.4	2,995,947.7
3	Нийт хөрөнгийн дүн	2,512,703.3	5,503,557.8	2,990,854.5
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,512,703.3	5,503,557.8	2,990,854.5
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,512,703.3	5,503,557.8	2,990,854.5

Авлага тайлант оны эцэст 4,076.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүний 2612.2 мянган төгрөг нь тухайн онд ерөнхий боловсролын хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосноос хамаарч 541.1 кг ямааны махыг удаан хугацаанд хадгалах боломж, нөхцөл бүрдээгүй учир нийлүүлсэн Хавтаг алтай хоршоонд буцаан өгч авлагаар бүртгэсэн, 1464.0 мянган төгрөг нь нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн авлагын үлдэгдэлтэй байна.

Бараа материалын данс оны эхэнд 92223.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 83054.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан. Эргэлтийн бус эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг данс бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 2771295.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант онд 3056203.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 5827498.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	2,771,295.2
2	Нэмэгдсэн	3,056,203.3
2.1	Худалдан авсан	500.0
2.5	Бусад	3,055,703.3
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,827,498.6
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	350,815.6

801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	60,255.7
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	411,071.2
11	Үлдэгдэл өртөг	5,416,427.4

Тайлант хугацаанд шинээр нэмэгдсэн хөрөнгийг тодруулбал: Төсвийн хөрөнгөөс 500.0 мянган төгрөгөөр камер худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 320 хүүхдийн суудалтай сургуулийн өргөтгөлийн барилгыг 2692588.8 мянган төгрөгөөр, хашаа, биеийн тамирын талбайг 305914.1 мянган төгрөгөөр, түүнчлэн Боловсрол соёл, урлагийн газраас нийт 54400.4 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл, тавилга эд хогшлыг, багш ажилчдын хандив тусламжаар 2800.0 төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Тус сургуулийн захирлын тушаал шийдвэрийн дагуу тооллогыг зохион байгуулсан боловч тооллогын үр дүнг үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.

Биет бус хөрөнгөд 1004.0 мянган төгрөгийн өртөгтэй, 1004.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй санхүүгийн программ хангамж, 20000.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 1910020.6 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3284142.5 мянган төгрөгөөр буюу 4.6 дахин өссөн байна. Хүснэгтээр харуулав:

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	918,047.7	4,202,190.1	3,284,142.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,550.0	2,400.0	(150.0)
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,183.3	3,053,883.8	3,035,700.6
122001	Хандив тусламж /дотоод/	-	5,660.0	5,660.0
1310	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	795,923.8	997,673.8	201,750.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,530.5	7,419.1	(31,111.4)
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,860.1	135,153.4	72,293.3

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 3053883.8 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 201750.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилт 72293.3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Нийт зардал өмнөх оноос 257808.3 мянган төгрөгөөр буюу 1.3 дахин өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		945,831.2	1,203,639.5	257,808.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	631,804.8	744,804.4	112,999.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,917.4	93,853.6	16,936.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,187.7	132,017.3	61,829.6
2104	Хангамж, бараа материалын зардал	14,408.5	17,142.0	2,733.5
2105	Нормативт зардал	45,680.2	31,935.9	-13,744.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,653.7	858.5	-4,795.2
2107	Томилолт, зочны зардал	349.6	00.0	-349.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249.7	392.0	142.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,119.7	68,248.2	-5,871.6

213	Урсгал шилжүүлэг	26,459.9	114,387.7	87,927.7
-----	------------------	----------	-----------	----------

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 129935.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 61829.6 мянга, урсгал шилжүүлэг 87927.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Дээрх зардлууд өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн, мөн тухайн онд сургуулийн өргөтгөл ашиглалтад орсноор байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өссөн, тухайн онд хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосноос хамаарч хоол хүнс, үдийн цайны хувьсах зардлуудын хэмнэлтийг буцаан төвлөрүүлснээр урсгал шилжүүлгийн зардал өсчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулга дансанд 9160.2 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтыг өмнөх оны үр дүн дансанд бүртгэжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1351900.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1351900.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 216672.8 мянган төгрөгөөр бууруулж 1135227.2 мянган төгрөгөөр тайлант оны төсөв баталсан нь өмнөх оны үзүүлэлтээс 274043.3 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оноос 200040.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 72075.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1135227.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 997673.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 135153.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2400.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 997673.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 135153.4 мянган төгрөгийн санхүүжилт бүрэн авч, туслах үйл ажиллагаанаас 2400.0 мянган төгрөгийн орлого, нийт 1135227.2 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 898777.9 мянган төгрөгийг зарцуулж, 100646.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1034580.7 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь Ковид-19 вирусын цар тахлын нөхцөл байдлын улмаас улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд зогсоосноос хамаарч нийт 100646.4 мянган төгрөгөөр хэмнэгджээ. Үүнд: Хоол хүнсний зардал 21757.8 мянга, үдийн цайны зардал 14152.7 мянга, цалин, НДШ-ийн зардал 63462.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71802	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	580,815.2	529,563.4	-51,251.8
71802	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	135,153.4	134,762.8	-390.6
71802	81801	Үдийн цай хөтөлбөр	26,429.9	12,277.2	-14,152.7
71802	81806	Дотуур байрны үйлчилгээ	148,915.1	120,249.0	-28,666.1
71802	81827	Бичиг үсгийн боловсролын хөтөл	11,172.8	10,458.4	-714.4
71802	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	232,740.8	227,270.0	-5,470.8

ДҮН

1,135,227.2 1,034,580.7 (100,646.4)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 3120.0 мянга, түрээсийн номын 3799.1 мянган төгрөгийн орлого, Боловсрол соёл, урлагийн газраас 500.0 мянган төгрөгийн санхүүжилт, нийт 7419.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, үүнээс 5955.1 мянган төгрөгийг холбогдох арга хэмжээнүүдэд зарцуулж, 1464.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож 149 мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бүрэн байршуулан мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1300.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1300.5	1	1300.5			100%
Зөвлөмж	1	8597.8	1	8597.8			100%
Нийт дүн	2	9898.3	2	9898.3			100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 19256.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11772.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 7484.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Өмнөх онуудад зарцуулагдсан боловч данс бүртгэлээс хасагдаагүй 9160.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг залруулж бүртгээгүй,

- Оны эхэнд данс бүртгэлээр байсан 541.1 кг ямааны махыг ерөнхий боловсролын хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосноос хамаарч Хавтаг алтай хоршоонд буцаан авах нөхцөлтэй өгсөн боловч авлагаар тусгаагүй,
- Нийт 11772. мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7484.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тус сургууль 2020 онд Тоосгон уул ХХК-ийн нэгдсэн халаалтын системээс дулааны эрчим хүчээр хангагдсан. Тухайн жилийн халаалтын батлагдсан төсөв 115309.3 мянган төгрөг байхад 147598.1 мянган төгрөгөөр дулааны эрчим хүч авахаар гэрээ байгуулсан байна. Гэвч батлагдсан төсвөөс хэтрүүлэн нэхэмжилсэн 32288.8 мянган төгрөгийн халаалтын тооцоог өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, тооцоо нийлж баримтжуулсан ч данс бүртгэлд өглөгөөр тусгаагүй байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй, түүнчлэн зарим эд хөрөнгийг багцалсан бөөн дүнгээр, тодорхойгүй нэршлээр данс бүртгэлд тусгасан алдаа, зөрчил байна.

1.2. Эрсдэл: Эд хөрөнгө дутагдах, санхүүгийн тайлан бүртгэл буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6- д "Нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв бүртгэж, тайлагнах" гэсэн заалтуудтай нийцүүлж эд хөрөнгийн нэршил, ангиллыг зөв тодорхойлох, түүнчлэн тооллогын үр дүнг холбогдох стандартад нийцүүлэн данс бүртгэлд үнэн зөвөөр тусгах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Сургуулийн спорт заалны 980.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүй зарцуулж хөрөнгө бэлтгэсэн байна.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Төсвийн захирагч хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх үүрэгтэй; гэсэн заалтуудтай нийцүүлэн өөрийн орлогыг бодитой төлөвлөж, төрийн сангийн харилцах дансаар дамжуулан хяналттай зарцуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			XOA-2021/137/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтай сумын ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч тооллогын үр дүнг тооцож данс бүртгэлд тусгаагүй, түүнчлэн зарим эд хөрөнгийг багцалсан бөөн дүнгээр, тодорхойгүй нэршлээр данс бүртгэсэн	6504.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Т.Цэцэгбадам, Э.Батзаяа
2	Сургуулийн спорт заалны 980.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүй зарцуулж хөрөнгө бэлтгэсэн,	980.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Т.Цэцэгбадам, Э.Батзаяа
3	Өмнөх онуудад зарцуулагдсан боловч данс бүртгэлээс хасагдаагүй 9160.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг залруулж бүртгээгүй	9160.2	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Т.Цэцэгбадам, Э.Батзаяа
4	Оны эхэнд данс бүртгэлээр байсан 541.1 кг ямааны махыг ерөнхий боловсролын хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосноос хамаарч Хавтаг алтай хоршоонд буцаан авах нөхцөлтэй өгсөн боловч авлагаар тусгаагүй,	2612.2	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Т.Цэцэгбадам, Э.Батзаяа
ДҮН		19256.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

